АЖМХ НЭЭХЭ, ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” НЭЗХЭ-ий ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

2023 он

2023 оны төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, журмуудын хэрэгжилт, батлагдсан төсвийн гүйцэтгэл, уялдааг судалж, тулгарч буй асуудлыг дүгнэх, эрсдлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил, дутагдлыг засаж сайжруулах чиглэлээр дүгнэлт, зөвлөмж өгөх зорилгоор “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” НЭЗХЭ дэргэдэх Хяналтын зөвлөлийн гишүүд 2024 оны 2-р сарын 27-29-ны 3 өдөр ажлын албаны өөрийн байранд хийлээ.

2024 он

АЖМХ НЭЗХЭ-ийн дүрмийн 41.1.12, хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны журмын 4.3-т заасны дагуу 2024 оны 10-р сарын 28-наас 30-ны хооронд санхүүгийн үйл ажиллагааны, түүний зарцуултанд хөндлөнгийн хяналтыг хийж гүйцэтгэсэн.

2025 он

АЖМХ НЭЗХЭ-ийн дүрмийн 41.1.12, хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны журмын 4.3-т заасны дагуу 2025 оны 3-р сарын 18-наас 3-р сарын 21-нд жилийн эцэс, 2025 оны 10-р сарын 20-ноос 10-р сарын 23-ны хооронд санхүүгийн үйл ажиллагаа, түүний зарцуултанд хөндлөнгийн хяналтыг хийж гүйцэтгэсэн.

НЭЗХЭ-ийн дэргэдэх ХЗ-ийн танилцуулга

Зөвлөл нь 2023.10.23-ны НЭЗХЭ-ийн бүх гишүүдийн хурлаар сонгогдсон бөгөөд нийт 9 гишүүний бүрэлдхүүнтэй зөвлөл болно.

НЭЗХЭ-ийн дэргэдэх ХЗ түүний дүрэм журам, эрх үүрэг

Хяналтын зөвлөлөөс 2025 оны 10 дугаар сарын 20-23-ны өдрүүдэд АЖМХ НЭЗХЭ-ийн ажлын албаны хурлын танхимд төлөвлөгөөт хяналтыг гүйцэтгэсэн болно. Гэвч 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр ажлын албанаас АЖМХ НЭЗХЭ-ийн үндсэн дүрмийн 40.1.1 заалтыг зөрчсөн тул хяналтын ажлыг зогсоосон болно.
Хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ дараах хууль, дүрэм, журам, заалтыг үндэслэв:

Үүнд:

- АЖМХ НЭЗХЭ-ийн дүрмийн 40 дүгээр зүйлд заасан “Хяналтын зөвлөлийн тухай 6 заалт бүхий эрх”,
- АЖМХ НЭЗХЭ-ийн дүрмийн 41 дүгээр зүйлд заасан “Хяналтын зөвлөлийн тухай 3 заалт бүхий үүрэг”,
- АЖМХ НЭЗХЭ-ийн дэргэдэх “Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 2 дугаар зүйлд заасан нийт 6 заалт бүхий эрх,
- АЖМХ НЭЗХЭ-ийн дэргэдэх “Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 3 дугаар зүйлд заасан нийт 6 заалт бүхий үүрэг,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалт.

Нэг. Удирдах зөвлөлийн гишүүдийн ирц, ажлын үр дүнд хяналт хийсэн тухай.

- АЖМХ НЭЗХЭ-ийн дүрмийн 24.1-д Удирдах зөвлөл “сар бүр нэгээс дээш удаа хуралдах”-аар заасан боловч 8-р саруудад ажлын албаны чиг үүргийн хүрээнд хуралдаагүй. Төлөвлөгөөт хугацаанд УЗ нийт 10 удаа хуралдсан ба гишүүдийн ирцийн мэдээллийг дараах хүснэгтэд харуулав.

№	Хуралдсан хугацаа	Оролцсон гишүүн	Ирц	Чөлөөтэй	Тасалсан
1	2024.12.12	20	69%	1	8
2	2025.01.02	21	72%	4	4
3	2025.01.23	17	59%	4	8
4	2025.02.10	21	72%	2	6
5	2025.03.19	22	76%	0	7
6	2025.04.17	21	72%	1	7
7	2025.05.22	17	59%	1	11
8	2025.06.05	20	69%	2	7
9	2025.07.31	16	55%	0	13
10	2025.09.26	16	55%	0	13

- Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 6.11-т Чиг үүргийн хороо “сар бүр нэг ба түүнээс дээш удаа хуралдах”-аар заасан. Үүнээс **Зах зээл, Хууль, Эрх зүй, Сургалт судалгааны чиг үүргийн хорооны** тайлантай танилцав. Зарим чиг үүргийн хорооны гишүүдийн хурлын ирцийн тэмдэглэл, хурлын тэмдэглэл, хурлын тогтоол, шийдвэрүүд, тайлан байхгүй.

- Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам, тус журмын 2 зүйлийн 2.3 дахь заалтын дагуу хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд ирээгүй УЗ-н гишүүдийн цахим хүсэлт болон УЗ-н даргын чөлөө олгосон шийдвэр байхгүй.

ЗӨВЛӨМЖ

НЭЗХЭ-н дүрмийн 22.3, 23.1.2, 23.1.4 заалтуудыг үндэслэн УЗ-ын дараах гишүүдэдийг эргүүлэн татах нөхцөл бүрдсэн.

- **Ц.Баатарсайхан нийт 10 удаагийн хуралд 0%-ийн ирцтэй**
- **Б.Барсболд нийт 10 удаагийн хуралд 40%-ийн ирцтэй**
- **Н.Батдарь нийт 10 удаагийн хуралд 20%-ийн ирцтэй**
- **Н.Батцэнгэл нийт 10 удаагийн хуралд 30%-ийн ирцтэй**
- **Б.Бямбадорж нийт 10 удаагийн хуралд 20%-ийн ирцтэй**
- **Д.Мөнхнаран нийт 10 удаагийн хуралд 30%-ийн ирцтэй**
- **Э.Цоморлиг нийт 10 удаагийн хуралд 10%-ийн ирцтэй**

- Бүх гишүүдийн хурлаас сонгогдсон гишүүд идэвхитэй байх, гишүүдийн эрх ашгийг бүрэн төлөөлөх
- Бүх гишүүдийн хурлаар сонгогдсон Удирдах Зөвлөлийн гишүүдийн ирц идэвхи, оролцоо хариуцлагатай байдлыг Удирдах зөвлөлийн даргын зүгээс сануулах,
- Аялал жуулчлалын оргил ачааллын үед чиг үүргийн хороод болон удирдах зөвлөлийн хурлын зохион байгуулалтыг өөрчилж тухайн үеийн ажлын албаны үйл ажиллагааны чиг үүргийг тодорхойлж удирдлагаар хангах ба үүнтэй холбоотойгоор журмын зохицуулалт хийх.

ДҮГНЭЛТ

Хоёр. Удирдах зөвлөлийн тогтоол, шийдвэрт хяналт хийсэн тухай.

- Удирдах зөвлөл 2025 онд 48 тогтоол шийдвэр гаргасан. 7 тогтоол нь албажаагүй, 1 тогтоолд нэмэлтээр тайлбар бичиг баримтууд хянан шалгах шаардлагатай байна гэж дүгнэв.
- Тогтоол тус бүрт дүн шинжилгээ хийхэд дараах алдаа дутагдал, зөрчилүүд илэрч байна. Үүнд:
- 2025.01.23 А/08/25 – Маркетинг цахим шилжилтийн чиг үүргийн хорооны тэргүүнийг чөлөөлөх, томилох тухай /УЗ дарга Б.Золбадрал өөрийгөө томилж баталгаажуулсан/ үүнд тайлбар авах

ЗӨВЛӨМЖ

- АЖМХ НЭЗХЭ-н дүрмийн 13.3. Жилийн гишүүнчлэлийн татварыг нэгдүгээр улиралд багтаан төлнө гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулж ажиллах,
- Салбар холбоод НЭЗХЭ-ийн ажлын албанд төлөвлөгөө, тайлан, гишүүнчлэл, татвар төлөлттэй холбоотой мэдээллийг эмх цэгцтэй хүлээлгэж өгөх,
- Салбар холбоодын төлөвлөгөө, тайлан, татвар төлөлттэй холбоотой бичиг баримтыг ажлын албаны хариуцсан ажилтан эмх цэгцтэй, бүрэн гүйцэд хүлээн авах,
- Салбар холбоодын саналын эрхтэй холбогдуулан гишүүний татвараа дүрэмд зааснаар төлөөгүй салбар холбоодын саналын эрхийг хүчингүй болгох зэрэглэл бууруулах.

ДҮГНЭЛТ

Гурав. Салбар холбоодын статус, хийсэн ажлын тайланд хяналт хийсэн тухай.

- АЖМХ НЭЗХЭ-ийн ажлын албанаас бэлтгэсэн материалд нийт 17 бүрэн эрхт салбар холбоо тайлан мэдээ илгээхээс ХЯТАД ЗАХ ЗЭЭЛ, ТӨВ АЙМАГ, СОЛОНГОС, ДОРНОГОВЬ, ХӨТӨЧ ТАЙЛБАРЛАГЧ ЖУУЛЧИН ТЭЭВЭР, ЖУУЛЧНЫ БААЗ салбар холбоод тайлан мэдээ ирүүлсэн үлдсэн буюу 10 салбар холбоод тайлан мэдээгээ ирүүлээгүй байна.

НЭГСЭН ДҮГНЭЛТ

- ХОЛБООНЫ НИЙТ гишүүдийн татвар төлөлт 50% нь хангалтгүй бөгөөд Удирдах зөвлөл гишүүдэд чиглэсэн идэвхижүүлэх үйл ажиллагаа хангалтгүй зохион байгуулсан
- Шинэ холбооны бүтэц зохион байгуулалт ач холбогдлыг бүрэн гүйцэд тайлбарлан таниулаагүй.
- Шинэ гишүүдийн дасан зохицох бойжуулалтын шатыг орхигдуулсан.

Ажлын албаны архив, бичиг хэргийн бүрдэл, бүртгэлжүүлэлт, хөтлөлт хяналт хийсэн тухай

- 2025.10.20-24-ны өдрийн хооронд төлөвлөгөөт хяналтын явцад Аялал жуулчлалын Мэргэжлийн Холбооны дараах бичиг баримтуудад архив, бичиг хэргийн бүрдэлтэй танилцсан болно. Үүнд:

№	Баримт, бичгийн төрөл	Хугацаа		Нийт	Үнэлгээ
		2025 он /1-р улирал/	2025 он/ 2-р улирал/		
1	Ирсэн бичиг	55	118	173	хангалттай
2	Явуулсан бичиг	103	158	261	хангалттай
3	А тушаал	6	18	24	Хангалттай бус
4	Б тушаал	14	36	50	Сайн
6	Гэрээ	26	25	51	Сайн
7	Хүний нөөцийн хавтас	13 ажилтан			хангалттай

Танилцсан бичиг баримтын төрөл тус бүрд дараах дүгнэлт өгөв. Ингэхдээ 1 дугаараар ерөнхий дүгнэлт, явцыг, 2 дугаараар сайжирсан зүйлсийг, 3 дугаараар дутагдалтай зүйлсийг, 4 дугаараар анхаарах зүйлс, зөвлөмжийг тэмдэглэв.

- **Ирсэн албан бичиг:**

1) 2025.06.01 - 2025.10.20 хооронд ирсэн 173 албан бичгийн бүртгэл, шийдвэрлэлттэй танилцав.
2) Албан бичгийн бүртгэлжүүлэлт сайжирсан, 2025 оноос албан бичиг бүрт бүртгэлийн карт ашигладаг болсон, цахим шуудангаар ирсэн хариутай хүсэлтийг бүртгэж шийдвэрлэдэг болсон зэргээр өгсөн зөвлөмжүүдийг сайн хэрэгжүүлсэн байна.
3) Бүртгэлийн дэвтэрт огноо болон дэс дараалал зөрсөн, давхардан дугааралсан мөн огт хамаарал бус гэрээ хавсаргасан ,шийдвэрлэлтийн явц, хариутай эсэхийг бүрэн тэмдэглэж, хөтлөөгүй зэрэг дутагдал байна.
4) Дотоод албан нэгж, ажилтанаас ирсэн өргөдөл, цалин, чөлөө, хүсэлт нь хувь хүний нууцыг агуулж байгаа учраас цаашид тусдаа бүртгэж, шийдвэрлэх байхыг зөвлөж байна. Чөлөө хүссэн, ээлжийн амралт эдлэх хүсэлт зэрэг дотоод нэгж, ажилтанаас ирсэн хүсэлтүүд бусад байгууллагаас хамт ирсэн албан бичигтэй хамт бүртгэгдсэн байдал нэлээдгүй хэд байна.

- **Явуулсан албан бичиг:**

1) 2025.06.01 – 2025.10.20 хүртэл 261 албан бичигтэй танилцсан болно.
2) Албан бичигийн бичиглэл, бүртгэл, дугаарлалт сайжирсан байна.
3) 2025 оны 1-р улиралд хийсэн хяналтаар, 2025 оны зарим албан бичигт хавсралт хуудасны тоог заагаагүй, мөн бүртгэлийн дэвтэрт хариутай эсэхийг тэмдэглээгүй зэрэг дутагдалууд илэрсэн байсан бол 2-р улиралд энэ байдлаа зассан харагдаж байна.

- **А тушаал:**

1) 2025.06.01 - 2025.10.20 хүртэл 20 ширхэг тушаалтай танилцав.
2) Үүнд тушаал хөтлөлт замбраагүй дугаарлалт давхацсан мөн тодорхой бус Хяналтын зөвлөлийн өмнөх дүгнэлтээр өгсөн “ажил, үйлчилгээ тус бүрээр тушаал гаргах”, тушаалын хүрээнд хөрөнгө гаргаж, гэрээ байгуулах, өндөр дүнтэй арга хэмжээнүүдийг задаргааг ойлгомжтой болгох” тал дээр хангалтгүй байсан ба өмнө нь өгсөн анхааргуулыг Сайжруулсан зүйлс байхгүй байсан болно.
3) А тушаалд дараах дутагдалууд илэрч байна. Үүнд:
   - А тушаалтай Б тушаалууд холигдсон болон дугаарлалт ойлгомжгүй 2025 оны А73, А80 зэрэг тушаалууд дугаарлалтын зөрчилтэй байсан болно
   - Яамнаас ирсэн тушаал болон яамтай байгуулсан гэрээг үндэслэн А тушаал гаргахгүйгээр гэрээ байгуулж, хөрөнгө зарцуулсан байна. Үүнээс болж Яамны тушаал, гэрээний задаргаа нь зөрсөн, үйл ажиллагаанд хүндрэл гарсан, мөн гадаад үзэсгэлэнгийн үеэр ажилласан байгууллагын ажилтангууд томилолтын зардлаа авч чадалгүй хохирсон гэх мэт дутагдлууд илэрсэн. Мөн А тушаал үйлдээгүйн улмаас санхүүгийн бичиг баримтууд дээр гарсан зарлага гүйлгээг хянахад хүндрэл үүсгэж байна.
4) Цаашид дараах ажлуудыг хэрэгжүүлэхийг зөвлөж байна
   - Цаашид дотогшоо чиглэсэн үйл ажиллагааны тушаалыг Б ангиллаар гаргаж байх
   - Ажил тус бүрээр А тушаал гаргаж, тухайн тушаалыг үндэслэж гэрээ байгуулж байх, тушаалаар зардлын задаргааг нарийвчилж баталж байх
   - Яамны тушаалаар батлагдсан зардлын задаргаа өөрчлөгдөх бол тодотгож дахин А тушаал гаргаж байх

- **Б тушаал:**

1) 2025.06.01 - 2025.10.20 хүртэл нийт 50 тушаалтай танилцав.
2) Дотоод үйл ажиллагаанд чиглэсэн Б тушаалуудын бүрдэл сайжирсан, дараалал алдагдаагүй, үйл ажиллагаа тус бүрээр тушаал гаргаж албажуулсан зэргээр сайжирсан байна.

- **Гэрээ:**

1) 2025оны эхний хяналт болон 2-р улиралд Өндөр дүнтэй гэрээнүүд, 2025 оны 06-р сарын 01-ээс 10-р сарын 20 хүртэлх бүх гэрээг сайн хянаж, гэрээний үндэслэл хэсэгт тухайн гэрээгээр зохицуулсан асуудлыг тодорхой бичиж, мөнгөн дүнг хавсралт болон үндсэн хэсэгт тодорхой бичдэг болсон, гэрээ бүрт “гэрээ дүгнэсэн акт” хавсаргасан гэх мэт өмнөх дүгнэлтээр өгсөн зөвлөмжийг сайн хэрэгжүүлсэн байна.

- **Хүний нөөцийн хавтасын бүрдэл:**

1) Одоо ажиллаж байгаа 13 ажилтны ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, анкет зэрэг материалуудыг хавтасласан байна. Ажилтан тус бүрийн хувийн мэдээллийг бүртгэлжүүлсэн, ойлгомжтой, цэгцтэй болгосон байна.

Үндсэн хөрөнгийн бүртгэл

Үндсэн хөрөнгийг бүртгэхдээ өмнөх онтой харьцуулахад картжуулж сайжруулсан байна. Гэвч зарим эд материалыг хүн тус бүр дээр картжуулж бүртгэх шаардлагатай байна.

АЖМХ НЭЗХЭ-ийн үндсэн хөрөнгө болох www.mto.mn вэб сайт нь 2025 онд санхүүгийн бүртгэлд бүртгэлжүүлж хүлээн авсан байна.

Энэ вэб сайтын бүтэц зохион байгуулалт, агуулга, хүртээмжтэй байдлыг дотоод болон гадаад орчинд ойлгомжтой байхаар нэмж сайжруулах шаардлагатай.

WEB SITE

MTO.mn сайт нь Монгол Улсын аялал жуулчлалын салбарыг Монгол улсдаа төдийгүй, дэлхийд төлөөлөх үндсэн зорилготой, салбарын өнөө цагийн мэдээ, мэдээлэл, статистик, үзүүлэлт, арга хэмжээний нэгдсэн санг бүрдүүлэхэд чиглэсэн цахим хуудас. Энэхүү платформ нь АЖ-ын салбарын мэдээллийг:

• Нэгтгэх, • Бүртгэлжүүлэх, • Чанаржуулах, • Стандартжуулах зорилготой.

Тиймээс өнөө цагийн цахим орчны эрчимтэй хөгжил, олон улсын хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг харгалзан, MTO.mn сайтыг дараах чиглэлээр улам сайжруулах шаардлага бий гэсэн саналыг хүргэж байна.

• Гадаадын хэрэглэгчдэд ойлгомжтой, чанартай орчуулгын систем (Англи хэл), бусад олон хэл рүү хөрвүүлэх боломжийг нь сайжруулах (100% орчуулгатай байлгах)

• Бүх төрлийн мэдээ, мэдээлэл, бодлого, үйлчилгээ, арга хэмжээг чанарын өндөр түвшинд, цэгцтэй бүтэцтэйгээр, нээлттэй хүргэх (Гадаад, Дотоод руу чиглэсэн)

• Монголын аялал жуулчлалын мэдээллийг дэлхийн өнцөг булан бүрээс хүссэн үедээ хялбар, ойлгомжтой, итгэлтэйгээр авах боломжийг хангах

• Уламжлалт мэдээллийн эх сурвалцуудаас давсан, шуурхай, баталгаатай, хэрэглэгч төвтэй платформ болгон хөгжүүлэх

Ингэснээр MTO.mn нь Монгол Улсын аялал жуулчлалыг дэлхийд зөв, бодитой, чанартайгаар таниулах, үндэсний хэмжээний цахим гүүр болж, олон улсын хэрэглэгчдийг татах, салбарын нэр хүндийг өсгөх чухал сувгуудын нэг болгох бүрэн боломжтой.

Гадаад үзэсгэлэн, Дотоод төсөл хөтөлбөр 2025 он

Гадаад үзэсгэлэнгийн жагсаалт:

- "IFTM Top Resa" Парис хотод болсон ОУ-н үзэсгэлэн
- "SITF 2025" БНСУ-ын нийслэл СӨҮЛ хотод болсон үзэсгэлэн
- "COTTM-2025" Бээжингийн ОУ-н АЖ-н үзэсгэлэн
- “ITB BERLIN” 2025 Герман улсын Берлин хотод зохион байгуулагдсан ОУ-ын АЖ-ын үзэсгэлэн
- Lets Travel-2025. Москва хотод болсон ОУ-ын АЖ-ын үзэсгэлэн

Хөтөлбөр, арга хэмжээ:

- ARA фестиваль
- Go Mongolia уриан дор Мөсөн сийлбэрийн ОУ-ын уралдаан
- Tourism Week 2025 арга хэмжээ (Дутуу хянагдсан)
- Go Mongolia арга хэмжээ (Хянагдаагүй)

Гадаад үзэсгэлэнд оролцсон компаниуд жагсаалт 2025 он

- **IFTM Top Resa (Парис, Франц) 2025.09.23 - 09.25**
  - ✓Төсөв: 70,000,000₮
  - ✓Оролцсон компани: (5)
    - ДМД Монгол ХХК,
    - Степиндимсе ХХК,
    - Анлок Степ Монголиа ХХК,
    - Монгол талын мэлмий ХХК,
    - Номад Планет ХХК
  - ✓Татвар төлөлт: Номад Планет ХХК 2024.04.05 (2025 оноо төлөөгүй)
  - ✓Зөрчил: Тухайн үед дүрмийн зөрчил гаргасан.

- **SITF 2025 (Сөүлийн ОУ-н үзэсгэлэн) 2025.06.05 - 06.08**
  - ✓Төсөв: 100,000,000₮
  - ✓Оролцсон компани: (9)
    - GS Tour Mongolia,
    - Mongolian Vision Tours,
    - ETU Travel,
    - Nomeco,
    - Joy Mongolia Travel,
    - Let’s Travel
    - IDC Tours,
    - Expat Adventure Mongolia,
    - Explore Mongolia
  - ✓Татвар төлөлт: Бүгд төлсөн
  - ✓Зөрчил: Гараагүй

Гадаад үзэсгэлэнд оролцсон компаниуд жагсаалт 2025 он

- **COTTM-2025 (Бээжин, Хятад) 2025.04.24 – 04.26.**
  - ✓ Төсөв: **170,000,000₮**
  - ✓ Оролцсон компани: (10)
    - Shine zuuch Travel,
    - AB Travel,
    - Adventure Mongolia,
    - Active Mongolia,
    - Huvsgul Travel,
    - Eyeland Travel,
    - Otgoodor,
    - New Juulchin Tours,
    - GS Tour,
    - ETU Travel
  - ✓ Татвар төлөлт: Бүгд төлсөн.
  - ✓ Зөрчил: Гараагүй.

- **ITB BERLIN 2025 (Берлин, Герман) 2025.03.04 – 03.06.**
  - ✓ Төсөв: **273,000,000₮**
  - ✓ Оролцсон компани: (14)
    - Nona Travel Mongolia,
    - Juulchin World Tours,
    - Duroo Travel LLC,
    - Rara Avis Travel,
    - Tsolmon Travel LLC,
    - Unlock Steppe Mongolia,
    - Explore Mongolia,
    - Amicus LLC,
    - Juulchin LLC,
    - Peace Wind LLC / Golden Gobi Tours,
    - Great Gengis Tours Expeditions,
    - Ider Expeditions LLC,
    - MTO,
    - Ulaanbaatar City Tourism Department
  - ✓ Татвар төлөлт: Бүгд төлсөн.
  - ✓ Зөрчил: Гараагүй.

- **Lets Travel-2025 (Москва, ОУ-н үзэсгэлэн) 2025.06.10 – 06.15**
  - ✓ Төсөв: **80,000,000₮**
  - ✓ Оролцсон компани: (2)
    - Pax Mongolia
    - Хишиг Даймонд
  - ✓ Зөрчил: Гараагүй

Хөтөлбөр, арга хэмжээний товч мэдээлэл

- **ARA фестиваль**
  - ✓Төсөв: 19,000,000₮
  - ✓Зөрчил: Гараагүй.
- **Мөсөн сийлбэрийн ОУ-н уралдаан**
  - ✓Төсөв: 220,000,000₮
  - ✓Зөрчил: гараагүй
- **Tourism Week-2025**
  - ✓Төсөв: 300,000,000₮
  - ✓Зөрчил: дутуу хяналт
- **Go Mongolia**
  - ✓Төсөв: тодорхойгүй
  - ✓Зөрчил: хяналт хийгдээгүй

2025 оны Гадаад үзэсгэлэн, Дотоод төсөл хөтөлбөр, арга хэмжээний дүгнэлт:

❑ **Олон улсын үзэсгэлэн:** 2025 онд нийт 5 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн зохион байгуулагдсан бөгөөд үүнд Парис, Сөүл, Бээжин, Берлин, Москва хотууд багтсан.

✓ Үзэсгэлэн бүрийн төсөв болон олгосон санхүүжилт бүрэн таарч, нийт төсөв: **693,000,000₮**.

❑ **Хөтөлбөр, арга хэмжээ:** 2025 онд ARA фестиваль, Мөсөн сийлбэрийн ОУ-н уралдаан, Tourism Week, Go Mongolia зэрэг 4 хөтөлбөр, арга хэмжээ зохион байгуулагдсан.

✓ Нийт төсөв: **529,000,000₮**

✓ Үүнээс ARA фестивальд **228,000₮-ийн хэмнэлт** гарсан.

✓ Зарим арга хэмжээ хянагдаагүй буюу дутуу хяналттай байсан.

❑ **Нийт төсөв:** Олон улсын үзэсгэлэн болон хөтөлбөр, арга хэмжээний нийт төсөв: **1,233,000,000₮**.

❑ **Зөрчил, анхаарах асуудал:**

✓ Зарим арга хэмжээ хянагдаагүй буюу хяналт дутуу байсан.

✓ Парисын үзэсгэлэнд оролцсон “Номад Планет” ХХК гишүүнчлэлийн татвараа 2024 онд төлсөн байсан нь журмыг зөрчсөн оролцоо байсан. **Жич:** Европ Зах зээлийн даргын тайлбарын дагуу тухайн үед оролцох өөр компанийн сонголтгүй байсан тул оролцуулсан.

✓ Цаашид АЖМХ НЭЗХЭ-ийн дүрмийн дагуу гишүүнчлэлийн татвараа төлсөн тур операторыг л арга хэмжээнд оролцуулах, дүрэм журмаа мөрдөн хэрэгжүүлэх шаардлагатай.

2024 оны төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн мэдээлэл

❑ Хэрэгжилтийн ерөнхий тойм

АЖМХ НЭЗХЭ нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулсан “Төрийн зарим чиг үүргийг нийтийн эрх зүйн хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх тухай” гэрээний дагуу 2024 онд нийт 24 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.

Эдгээр хөтөлбөрийн нийт санхүүжилтийн хэмжээ 629.8 сая төгрөг бөгөөд тайлангаар баталгаажсаны дагуу 537.9 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, 250.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хэрэгжүүлсэн нийт хөтөлбөрөөс 11 хөтөлбөрийг АЖМХ НЭЗХЭ удирдан зохион байгуулсан байна.

❑ Хэрэгжилтийн ахиц, сайжруулалт

2023 оны эцсийн хяналтын дүгнэлтэд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсний үр дүнд төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн дансыг гишүүний татварын данснаас салган, санхүүгийн бүртгэлийн үйл ажиллагааг шинэчилж, ил тод байдлыг нэмэгдүүлсэн нь бүртгэлийн чанарт мэдэгдэхүйц ахиц гаргасан байна.

❑ Илэрсэн хүндрэл, дутагдал

2024 онд хэрэгжүүлсэн хяналт шинжилгээ, үнэлгээний явцад дараах хүндрэл илэрсэн байна.

Үүнд:

- ✓ Гэрээт нягтлан бодогч Эрдэнэ нь өвчний шалтгаанаар улирлын болон жилийн төлөвлөгөөт хяналт шалгалтын үеэр ажил дээрээ байгаагүй тул зарим санхүүгийн гүйлгээнд шаардлагатай тайлбар, тодруулгыг авч чадаагүй.
- ✓ Зарим хөтөлбөрийн санхүүгийн бүртгэлд баримтжуулалт дутуу, цэгцлэлт шаардлагатай тохиолдлууд илэрсэн.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД

“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” НЭЗХЭ

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
2023 - 2025 он

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

2023 он

АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ

- Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль, тогтоомж, хамтын гэрээ болон үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж буй хууль, тогтоол, тушаал, заавар, журмын хэрэгжилт
- Харилцах болон бэлэн мөнгөний зарцуулалтын анхан шатны баримтын бүрдүүлэлт, хууль эрх зүйн үндэслэл зарцуулалт, үр дүн, тайлан
- Данс бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн журнал хөтлөлт
- Эд хариуцагчийн бараа материалын тайлан тооцоо
- Ажиллагчдын цалин хөлсний бодолт, олголт, баримтын бүрдүүлэлт

2023 он
ОРЛОГЫН БҮРДЭЛТ

№	ОРЛОГЫН ТӨРӨЛ	Дүн /сая.төг/
1	Гишүүдийн татвар	64.9
2	Төсөл, хөтөлбөр	538.6
3	Хандив	5
4	Спорт арга хэмжээ	8
5	Бүх гишүүдийн уулзалт	6.3
	Дүн	**622.8**

2023 ОН

Харилцах болон бэлэн мөнгөний зарцуулалтын баримтын бүрдүүлэлтийн тухай:

ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ЗӨВЛӨМЖ

- Анхан шатны баримтуудыг дугаарлаагүй, хавсаргасан зарим баримтын бүрдэл дутуу.
- Кассын баримтын иж бүрдэл дутуу зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зураагүй тамга, тэмдэг дараагүй, хүчин төгөлдөр бус баримтууд байсан.

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно гэж заасан тул анхан шатны баримтыг сар, улирлаар үдэх, архив албан хэрэг хөтлөлтийн журмыг мөрдөн ажиллах
- Гүйлгээ гарсны дараах баримтыг бүрэн хавсаргаж байх, мөн зохих албан тушаалтнаар хянуулж, баталгаажуулах

2023 ОН

Санхүүгийн тайлагналын талаар:

ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ЗӨВЛӨМЖ

- 2023 оны Санхүүгийн тайлан харъяалах санхүүгийн байгуулага нь илгээх шаардлагагүй гэж зөвлөсний үндсэн илгээгүй гэсэн хариулт нягтлан бодогч өгсөн.
- Нягтлан бодогчийн Гүйлгээ балансад гаргасан орлогын дүн ААНОТ тайлангийн илгээсэн орлогын дүн зөрсөн. Татварын програмын алдааны улмаас зарим нэхэмжлэх, баримт нь татагдаж орж ирээгүй алдаатай холбоотой дүн зөрсөн.
- Цахим баримт шивэгдээгүй гүйлгээнүүдийг Дансны авлага дансанд андуурч бүртгэсэн.
- 2023.11.23-д авлага, өглөгийн гүйлгээ хаагаагүй.

- Төрийн бус байгууллагын тухай хуулийн 23.2.1-5 заасны дагуу тайлан гаргахыг судлах
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1-т заасны аккруэл суурьиар хөтлөхтэй холбоотой Гүйлгээ балансын холбоотой талаас авах авлагын дүнгээр орлогыг өсгөж мэдүүлэх
- Анхан шатны баримтуудыг цаг тухай бүрт бүрдүүлж байх
- Гүйлгээ балансад тусгагдсан Гүйцэтгэгчээс авах авлага, Дансны авлага, Хувь хүнээс авах авлага, Ажиллагчдаас авах авлага дансанд бүртгэгдсэн гүйлгээнүүд нь цахим баримт бүрдүүлээгүй гүйлгээнүүд учир Урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэх нь зүйтэй.

2023 ОН

Бараа материалын хөтлөлт, тайлан, зарцуулалт

ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ЗӨВЛӨМЖ

- Шаардах хуудас, зарлагын баримт, орлогын баримтад холбогдох албан хаагчдын гарын үсэн зуруулаагүй.
- Үндсэн хөрөнгийг данслаж аваагүй.

- 2023 оны бараа материалыг шаардах хуудас үйлдэж, зарлагын баримт, орлогын баримтад холбогдох албан хаагчдын гарын үсэг зуруулж баримтжуулах
- Үндсэн хөрөнгийг данслаж эд хариуцагч нарт хүлээлгэж өгөх бүртгэл баримтууд үйлдэх

2023 ОН

Татвар, нийгмийн даатгал

ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ЗӨВЛӨМЖ

- Татварын тайлангууд мэдүүлж, илгээсэн. Нийгмийн даатгалын тайланг 11-р сараас мэдүүлж илгээж эхэлсэн. Гүйлгээ балансад жилийн эцсийн тайлангууд өглөгтэй гарсан

- Гадаад руу гарч байгаа гүйлгээнүүд цалин хөлстэй холбоотой бол Оршин суугч бус хувь хүний орлогын албан татвар мэдүүлдэг болохыг анхаарч, судлаж ажиллах
- Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн /2024.01.01/ 7.4.10-д өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан гэж заасны дагуу Нийгмийн даатгалын тайланг мэдүүлж, илгээх
- Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг өглөгийг хуулийн хугацаанд төлж барагдуулах

2023 ОН

Ажиллагчдын цалин хөлсний бодолт, олголт, баримтын бүрдүүлэлт

ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ЗӨВЛӨМЖ

- Ажлын албаны дарга нь 2023 оны 10-р сард ажилласан албан хаагчидтай байгуулсан гэрээ, тушаал байхгүй.
- Ажилчин, албан хаагчидтай байгуулсан гэрээ, хөдөлмөрийн гэрээ баталгаажуулаагүй.
- Ажилчин, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн мэдээ, цаг ашиглалтын бүртгэл байхгүй.

- Албан хаагчид, ажилтнуудтайгаа цаг тухай бүрд нь гэрээ байгуулж, баталгаажуулах, тушаал гаргах
- Албан хаагчид, ажилтнуудын ажлын гүйцэтгэл, цаг ашиглалтын мэдээллийн оновчтой систем ашиглан үнэлэлт дүгнэлт өгч ажиллах

“МТО” НЭЗХЭ-ийн Ажлын алба нь 2023 оны 10-р сард гэрээт 3, 11-р сард үндсэн 5, гэрээт 1, 12-р сард үндсэн 6, гэрээт 2 албан хаагчид, ажилтантай ажил үүргээ гүйцэтгсэн байна.

2023 оны жилийн эцсийн Гүйлгээ балансаар 18’198’848.82 төгрөгийн өглөгтэй гарсан байна. Үүнд:

- Цалин өглөг - 6’349’124.23
- ХХОАТ өглөг - 3’696’577.14
- НДШ өглөг - 4’045’985.45
- БХ өр төлбөр – 4’107’162.00

2023 ОН

Хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн мэдээлэл

№	Төсөл хөтөлбөрийн нэр	2023 оны батлагдсан төсөв		
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	БНСУ трэвел шоу	50,000,000	50,000,000	
2	ОХУ Байгаль тур үзэсгэлэн	5,384,190	5,384,190	
3	Үндэсний нөлөөлөгчидтэй хамтран ажиллах	100,000,000	52,519,900	47,480,100
4	Ногоон хөрөнгө оруулалтын чуулган	38,229,154.5	39,125,290	(896,135)
5	ОУ-н нөлөөлөгчидтэй хамтран ажиллах	345,000,000	241,500,000	103,500,000
	Дүн	**538,613,344.5**	**388,529,380**	**150,083,964.5**

2023 оны жилийн эцсийн Гүйлгээ балансад мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 112,474,179.5 байна. Эндээс үзэхэд төсөл, хөтөлбөрөө амжилттай хэрэгжүүлж дуусгахад 37,5 сая төгрөг дутагдаж байгаа нь харагдаж байна.

2023 ОН

ДҮГНЭЛТ

1. 2023 оны 10-р сараас 12-р сар дуустал гишүүдийн татвар 64,95 сая төгрөг бүрдсэн ба ажлын албаны үйл ажиллагааны зардалд 78,4 сая зарцуулагдсан нь зөвхөн гишүүдийн татвараар санхүүжигдан ажиллахад учир дутагдалтай харагдаж байна.
2. Хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн хувьд ажлын алба тодорхой хэмжээний нөөц хуримтлал үүсгэн, сайн төсөв, төлөвлөгөө гарган баримтлаж ажиллахгүй бол амжилттай, үр бүтээлтэй, хүртээмжтэй үр дүн гарахад санхүүгийн эрсдэлд орох магадлалтай байна.

2023 ОН

САНАЛ

- Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг хууль, дүрмийн дагуу өдөр тутам цаг хугацаанд нь хөтлөж гаргаж байхын тулд үндсэн орон тооны мэргэжлийн нягтлан бодогч авч ажиллуулах
- Хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт гишүүн байгуулагуудыг хүртээмжтэй үр дүнтэй хамруулж байх
- Орлого, зарлагын гүйлгээг гаргахад хянаж баталгаажуулах эрх бүхий албан тушаалтан дор хаяж 2 байх
- Үйл ажиллагааны чиглэлд хамаарахгүй зардал гаргахгүй байх тал дээр анхаарах
- Өндөр үнийн дүнтэй мөнгөн гүйлгээ хийх тохиолдолд Удирдах зөвлөлийн тогтоол, шийдвэрийг хавсаргах, тухайн тогтоолд Удирдах зөвлөлөөс үүрэг шийдвэрийг тодорхой тусгассан байх

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

2024 он

2024 он
ОРЛОГЫН БҮРДЭЛТ

№	ОРЛОГЫН ТӨРӨЛ	Дүн /сая.төг/
1	Гишүүдийн татвар	387.2
2	Төсөл, хөтөлбөр	5’693.3
3	Хандив	452.0
4	Бусад орлого	281.8
	Дүн	**6’814.3**

2024 ОН

Санхүүгийн тайлагналын талаар:

ЗӨРЧИЛ, ЗӨВЛӨМЖ

- Санхүүгийн тайлагналын хувьд анхны шатны баримтын бүртгэл хөтлөлтийг санхүүгийн программ данс андуурч шивсэн, буруу данс руу холбосон гэх мэт алдаануудаас шалтгаалж дансны дүн зөрүүтэй тайлагнагдсан.
- Урьдчилж төлсөн зардал дансанд 2’362.4 сая төгрөгийн өндөр дүнтэй үлдэгдэлтэй байна. Энэ нь зарим төсөл, хөтөлбөр дуусаагүй, түүнчлэн баримтын бүрдэл дутуу зэргээс хамаарч зардалд бүртгэгдээгүй шалтгаанууд байна.
- Орлогын дэлгэрэнгүй тайланд Гишүүдийн татвар 387,2 сая төгрөгөөр бүртгэгдсэн. Ибаримтын системээр тулгаж үзэхэд 405,0 сая төгрөг байгаа бөгөөд 22,8 сая төгрөгөөр зөрүүлж бүртгэсэн байна.
- 2024 оны 10-р сарын 02-нд 326 ширхэг модны суулгацын үнэ болох 15,7 сая төгрөгийг хувь хүнд олгосон боловч дансны бүртгэлийн Зардал дансыг Авлага данс руу андуурч бүртгэсэн.
- Нягтлан бодох бүртгэлийн хувьд нэлээн алдаатай бүртгэлүүд хийгдсэн байна.

- Анхан шатны баримтыг гүйлгээ гарч буй тухай бүрд нь бүрдүүлж баталгаажуулж байх
- Төрийн бус байгууллагын тухай хуулийн ТББ нь 20.1-д орлого зөвхөн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулна гэж заасны дагуу төсөл, хөтөлбөр үйл ажиллагаа бүрээр бүртгэл хөтлөх
- Ажил гүйлгээний бүртгэл, дансны холболтыг санхүүгийн программ шалгах, хянах, засварлах

2024 ОН

Мөнгө зарцуулалтын баримтын бүрдүүлэлтийн тухай:

ЗӨРЧИЛ, ЗӨВЛӨМЖ

- Гишүүдийн татварын 387,2 сая төгрөгөөс бүрэн эрхэт 8 салбар холбоонд 115,5 сая төгрөг олгосон байна.
- Мөнгөн гүйлгээний зарлага гаргах баримтуудын иж бүрдэл дутуу
- Мөнгөн гүйлгээний утга тодорхой бус.
- Зарим гүйлгээнүүд анхан шатны баримт бүрдүүлэлт дутуу, баталгаажуулаагүй.

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно гэж заасан тул анхан шатны баримтыг сар, улирлаар үдэх, архив албан хэрэг хөтлөлтийн журмыг мөрдөн ажиллах
- Гүйлгээ гарсны дараах баримтыг бүрэн хавсаргаж байх, мөн зохих албан тушаалтнаар хянуулж, баталгаажуулах
- Олон нийтийн байгууллагат байгууллагын карт ашиглаж зарлага гаргах нь хэр оновтой, хяналттай эсэх талаар удирдах зөвлөл анхааралд авч шийдвэр гаргах

2024 он

“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” НЭЗХЭ-ийн дэргэдэх Ажлын албаны санхүүгийн үйл ажиллагааны талаар

- 2024 онд АЖМХ-ны ажлын алба нь 823,2 сая төгрөгийн зарцуулалтын төсвийг батлуулан мөрдөн ажилласан байна.

2024 оны Ажлын албаны орлого, зарцуулалтын мэдээ

төлөвлөгөө, гүйцэтгэл /мян.төг/

	Орлого Гишүүдийн татвар	Орлого Хөтөлбөр, төсөл	Хөтөлбөр хэрэгжүүлэх зардал	Түрээс, ашиглалт	Харилцаа, холбооны зардал	Цалингийн зардал	Бичиг хэргийн зардал	Удирдлагын зардал /томилолт/	Үндсэн хөрөнгө авах
Төлөвлөгөө	529,200.00	6,198,700.	-	86,400.00	42,480.00	579,012.00	30,240.00	54,000.00	31,090.00
Гүйцэтгэл	387,220.00	5,693,288.	3,371,392.	86,899.20	49,145.01	517,106.61	18,110.56	40,595.28	22,153.80

төлөвлөгөө, гүйцэтгэл хувь

	Орлого Гишүүдийн татвар	Орлого Хөтөлбөр, төсөл	Хөтөлбөр хэрэгжүүлэх зардал	Түрээс, ашиглалт	Харилцаа, холбооны зардал	Цалингийн зардал	Бичиг хэргийн зардал	Удирдлагын зардал /томилолт/	Үндсэн хөрөнгө авах
Төлөвлөгөө хувь	100%	100%	0%	100%	100%	100%	100%	100%	100%
Гүйцэтгэл хувь	73%	92%	100%	101%	116%	89%	60%	75%	71%

2024 оны Ажлын албаны орлого, зарцуулалтын мэдээ

2024 онд Ажлын алба нь гишүүдийн татварын 529,2 сая төгрөг орлого, 823,2 сая төгрөгийн зардлын төсөв батлуулан, гишүүдийн татвараас 387,2 сая орлого олж, 734,1 сая төгрөгийн зарлагын гүйлгээ гаргасан байна.

Дээрх мэдээнээс дүгнэхэд:

- Зарлага төсөвтэй багтсан боловч гишүүдийн татвараас олох орлогын төсөөлөл 73%-ийн биелэлттэй байна.
- Харилцаа, холбооны зардал төсвөөс 16% илүү зарцуулалттай байна.
- Ажлын төсөвийг боловсруулахдаа бодлого, хөтөлбөр, зорилго чиглэлээ баримтлан, судалгаа арга зүйд үндэслэн өртөг, зардлыг оновчтой тооцож гаргах

2024 ОН

Татвар, нийгмийн даатгал

ТАЙЛАГНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Татварын тайлангуудыг мэдүүлж, илгээсэн.
- Нийгмийн даатгалын 2024 оны 12-р сарын тайланд өмнөх саруудад гэрээгээр ажил гүйцэтгэсэн хөдөлмөрийн хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөж тооцож, тайланд мэдүүлсэн.
- 2024 оны жилийн эцсийн тайлангаар 659,4 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тайланд гэрээгээр ажиллагсдыг тухайн мэдүүлж тайлагнаж байх
- Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг хуулийн хугацаанд төлж барагдуулах

2024 оны жилийн эцсийн Гүйлгээ балансаар 659,4 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна. Үүнд:

- Цалин өглөг - 7,4 сая, - 1%
- ХХОАТ өглөг - 19,8 сая - 3%
- НДШ өглөг - 15,4 сая – 2%
- БХ өр төлбөр - 616,8 сая – 94%

2024 ОН

Төсөл хөтөлбөр хэрэгжилтийн талаар

- АЖМХ НЭЗХЭ нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулсан “Төрийн зарим чиг үүргийг нийтийн эрх зүйн хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх тухай” гэрээний дагуу 2024 онд 24 хөтөлбөрийн 5’629,8 сая төгрөгийн гэрээний дагуу тайлангаар баталгаажуулан гүйцэтгэж, 5’379,8 төгрөгийг санхүүжилт хүлээн авч, 250 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Дээрх 24 хөтөлбөрөөс АЖМХ НЭЗХЭ-ээс 11 хөтөлбөрийг удирдан зохион байгуулж гүйцэтгэсэн байна.

2024 ОН

ДҮГНЭЛТ

- “АЖМХ” НЭЗХЭ-ийн гэрээт нягтлан бодогч н.Эрдэнэ өвчтэй шалтгаанаар байгаагүй учир зарим тодруулгыг авч чадаагүй болно.
- НББ-ын бүртгэлийг сайжруулах, санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах, нягтлан бодогчийг чадавхжуулах
- Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг хууль, дүрмийн дагуу өдөр тутам цаг хугацаанд нь хөтлөж гаргаж байхын тулд үндсэн орон тооны мэргэжлийн нягтлан бодогчтой санхүүгийн алба авч ажиллуулах шаардлагатай гэж дүгнэж байна.
- Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, гишүүдийн татвар авах дансуудыг салгаж хөтөлсөн нь өмнөх тайлантай харьцуулахад данс хөтлөлт сайжирсан гэж дүгнэв.
- Цаашид төсөл, хөтөлбөрийн бүртгэлийг тухайн хөтөлбөрийн гүйлгээ бүрээр санхүүгийн програмдаа тус тусд нь хөтлөх шаардлагатай.

2025 он
ОРЛОГЫН БҮРДЭЛТ

№	ОРЛОГЫН ТӨРӨЛ	Дүн /сая.төг/
1	Гишүүдийн татвар	332.1
2	Төсөл, хөтөлбөр	1’693.1
3	Бусад орлого	136.1
	Дүн	**2’161.3**

2025 ОН

Санхүүгийн тайлагналын талаар:

ЗӨРЧИЛ, ЗӨВЛӨМЖ

- Тус холбооны дэд данстай салбар холбоо болох Хятад зах зээлийн холбооны 169,9 сая, Европ зах зээлийн холбооны 815,1 сая төгрөгийн санхүүгийн гүйлгээний тайлан ирээгүй учир хөндлөнгийн хяналт хийгдээгүй болно.
- Санхүүгийн тайлагналын хувьд бусад зардал дансанд 39,9 сая төгрөгийн зардал бүртгэгдсэн. Энэ нь өмнөх жилүүдийн тайлангуудын алдааны залруулга, дансны буруу бүртгэл, баримтын бүрдэл дутуу зэргээс хамаарсан тодорхой бус гүйлгээнүүдийг бүртгэсэн байна.
- Урьдчилж гарсан зардал дансанд 531 сая төгрөгийн өндөрт дүнтэй үлдэгдэлтэй байна. Энэ нь зарим төсөл, хөтөлбөр дуусаагүй, түүнчлэн баримтын бүрдэл дутуу зэргээс хамаарч зардалд бүртгэгдээгүй шалтгаанууд байна.
- 364 сая төгрөгийн Урьдчилж орсон орлого дансны бүртгэлийг Дансны өглөг данс руу андуурч бүртгэсэн.
- Санхүү, татварын тайлангуудын өмнөх жилүүдийн алдааг санхүүгийн зөвлөх үйлчилгээний компаниар хянуулан, дахин засварлаж, мэдүүлэн баталгаажуулсан нь цаашид нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг зөв хийхэд дөхөм болох ажлыг гүйцэтгэсэн байна.

- Анхан шатны баримтыг гүйлгээ гарч буй тухай бүрд нь бүрдүүлж баталгаажуулж байх
- Ажил гүйлгээний бүртгэл, дансны холболтыг санхүүгийн программд шалгах, хянах, засварлах

2025 ОН

Мөнгө зарцуулалтын баримтын бүрдүүлэлтийн тухай:

ЗӨРЧИЛ, ЗӨВЛӨМЖ

- Гишүүдийн татварын 332.1 сая төгрөгөөс бүрэн эрхэт салбар холбоодод 48,6 сая төгрөг олгосон байна.
- Мөнгөн гүйлгээний зарлага гаргах баримтуудын иж бүрдэл дутуу
- Мөнгөн гүйлгээний утга тодорхой бус.

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно гэж заасан тул анхан шатны баримтыг сар, улирлаар үдэх, архив албан хэрэг хөтлөлтийн журмыг мөрдөн ажиллах
- Гүйлгээ гарсны дараах баримтыг бүрэн хавсаргаж байх, мөн зохих албан тушаалтнаар хянуулж, баталгаажуулах
- Олон нийтийн байгууллагад **байгууллагын карт ашиглаж зарлага гаргах** нь хэр оновчтой, хяналттай эсэх талаар удирдах зөвлөл анхааралдаа авч шийдвэр гаргах, гүйлгээний задаргааг нарийвчилж гаргах

2025 он

“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” НЭЗХЭ-ийн дэргэдэх Ажлын албаны санхүүгийн үйл ажиллагааны талаар

2025 онд АЖМХ-ны ажлын алба нь 1101,9 сая төгрөгийн зарцуулалтын төсвийг батлуулан мөрдөн ажиллаж байна.

2025.01.01 - 09.30 хүртэлх
Ажлын албаны орлого, зарцуулалтын мэдээ

Төлөвлөгөө, гүйцэтгэл /мян.төг/

	Орлого Гишүүдийн татвар	Орлого Хөтөлбөр, төсөл	Бусад орлого	Хөтөлбөр хэрэгжүүлэх зардал	Түрээс, ашиглалт	Харилцаа, холбооны зардал	Цалингийн зардал	НДШ-ийн зардал	Мэргэжлийн үйлчилгээний зардал	Бичиг хэргийн зардал	Удирдлагын зардал /томилолт/	Үндсэн хөрөнгө авах	Салбар холбоодын санхүүжилт
Төлөвлөгөө	621,00	4,000,	289,50	-	86,400	91,200	330,00	54,756	73,200	52,000	89,900	14,000	310,50
Гүйцэтгэл	332,09	1,693,	136,14	1,348,	78,630	9,995.	309,91	45,807	56,725	7,108.	27,756	22,314	48,600

Төлөвлөгөө, гүйцэтгэл хувь

	Орлого Гишүүдийн татвар	Орлого Хөтөлбөр, төсөл	Бусад орлого	Хөтөлбөр хэрэгжүүлэх зардал	Түрээс, ашиглалт	Харилцаа, холбооны зардал	Цалингийн зардал	НДШ-ийн зардал	Мэргэжлийн үйлчилгээний зардал	Бичиг хэргийн зардал	Удирдлагын зардал /томилолт/	Үндсэн хөрөнгө авах	Салбар холбоодын санхүүжилт
Төлөвлөгөө хувь	100%	100%	100%	0%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%
Гүйцэтгэл хувь	53%	42%	47%	100%	91%	11%	94%	84%	77%	14%	31%	159%	16%

2025 оны Ажлын албаны орлого, зарцуулалтын мэдээ

2025 онд Ажлын алба нь гишүүдийн татварын 1110,5 сая төгрөг орлого, 1101,9 сая төгрөгийн зардлын төсөв батлуулан, 2025 оны 9-р сарын 30-ны байдлаар 552,9 сая сая орлого олж, 606,9 сая төгрөгийн зарлагын гүйлгээ гаргасан байна.

Дээрх мэдээнээс дүгнэхэд:

- 2025.09.30-ны байдлаар Төсвийн орлогын төсөөлөл 44%, зардлын төсөөлөл 55,1% биелэлттэй байна.
- 2025.09.30-ны байдлаар орлогоосоо зарлага нь давсан төсөвтэй байна.
- Үндсэн хөрөнгө авах зардал төсвөөс 59% илүү зарцуулалттай байна.
- Ажлын төсөвийг боловсруулахдаа бодлого, хөтөлбөр, зорилго чиглэлээ баримтлан, судалгаа арга зүйд үндэслэн өртөг, зардлыг оновчтой тооцож гаргах

2025 оны 3-р улирлын Гүйлгээ балансаар 607,5 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна. Үүнд:

Өглөг дүн

- ХХОАТ өглөг – 7,8 сая
- НДШ өглөг – 28,1 сая
- БХ өр төлбөр- 571,6 сая

2025 ОН

Төсөл хөтөлбөр хэрэгжилтийн талаар

- АЖМХ НЭЗХЭ нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулсан “Төрийн зарим чиг үүргийг нийтийн эрх зүйн хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх тухай” гэрээний дагуу 2025 онд 12 хөтөлбөрийн 1’996,1 сая төгрөгийн гэрээг хийж, 1623,1 төгрөгийг санхүүжилт хүлээн авч, 373 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2025 ОН

ДҮГНЭЛТ

- Тус холбооны дэд данстай салбар холбоодын санхүүгийн тайлан, ажлын гүйлгээг цаг тухайд нь бүртгүүлэх, хянуулахад анхаарах
- Бусад зардал дансанд бүртгэгдсэн ажил гүйлгээг тодруулах, бүртгэлийг цэгцлэх
- ПОС-оор хийгдсэн болон карт уншуулсан гүйлгээний задаргааг нарийвчилан гаргах
- Үндсэн хөрөнгийн тоо хэмжээг салгаж бүртгэх, картлаж хаягжуулах
- Голомт банкны дансны нэрийг ижил болгох
- НББ-ын бүртгэлийг сайжруулах, санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах,

2023, 2024, 2025.09 сар
САНХҮҮГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ХАРЬЦУУЛАЛТ /сая,төг/

ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ХАРЬЦУУЛАЛТ /сая,төг/

ӨР ТӨЛБӨРИЙН ҮЛДЭГДЭЛ

ЗӨВЛӨМЖ

- АЖМХ НЭЗХЭ-н дүрмийн 13.3. Жилийн гишүүнчлэлийн татварыг нэгдүгээр улиралд багтаан төлнө гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулж ажиллах,
- Салбар холбоод НЭЗХЭ-ийн ажлын албанд төлөвлөгөө, тайлан, гишүүнчлэл, татвар төлөлттэй холбоотой мэдээллийг эмх цэгцтэй хүлээлгэж өгөх,
- Салбар холбоодын төлөвлөгөө, тайлан, татвар төлөлттэй холбоотой бичиг баримтыг ажлын албаны хариуцсан ажилтан эмх цэгцтэй, бүрэн гүйцэд хүлээн авах,
- Салбар холбоодын саналын эрхтэй холбогдуулан гишүүний татвараа дүрэмд зааснаар төлөөгүй салбар холбоодын саналын эрхийг хүчингүй болгох.

ЗӨВЛӨМЖ

- АЖМХ-ны дэргэдэх Хяналтын зөвлөлийн 2023, 2024, 2025 оны тайлан нэгтгэлийг www.mto.mn вэб сайт дээр байршуулж тайланг бүх гишүүдэд нээлттэйгээр үзэж танилцдаг болгох
- АЖМХ-ны дэргэдэх салбар холбоодын Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлийн гишүүд холбооны дүрэм журамтай бүрэн дүүрэн уншиж танилцах
- Зарим салбар холбоод гишүүний татвар төлөөгүй, гишүүн бус байгууллага салбар холбооны хяналтын зөвлөлд ажиллаж байгаа тул яаралтай салбар холбооноос чөлөөлж нөхөн сонгууль явуулах

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА